



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/116

Улаанбаатар хот

Эзэмшиж буй газрын зориулалт
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.6, 21.2.7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/253 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зориулалт өөрчлүүлэхээр хүсэлт гаргасан 1 (нэг) иргэний газрын зориулалтыг хавсралтад зааснаар өөрчилсүгэй.

2.Газрын зориулалт өөрчлүүлж буй иргэнтэй холбогдох хууль, тогтоомж эрхийн актын дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, хэрэгжилтэд нь хяналт тавьж, ажиллахыг Багахангай дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/187 дугаар захирамжийн Н.Оюунчимэгт хамаарах заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД